



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ
ТЭМДЭГЛЭЛЭС**

2025 оны 07 сарын 04 өдөр

Дугаар 11

Улаанбаатар хот

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2025 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн хуралдааны тэмдэглэлд:

“ХЭЛЭЛЦСЭН нь: “Дулааны III цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компанид гарсан аваар, осолтой холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай

ТЭМДЭГЛЭСЭН нь:

“Дулааны III цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компанид 2025 оны 06 дугаар сарын 02-ны өдөр гарсан аваар, осолтой холбогдуулан үйл ажиллагааг нь хэвийн горимд шилжүүлж, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор Засгийн газрын 2025 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн 03 дугаар тогтоож тус компанийд 6 сарын хугацаагаар онцгой дэглэм тогтоосон. компанийн үндсэн үйл ажиллагаа, зохион байгуулалтыг шууд хариуцан удирдаж, төлөөлөх эрх бүхий Засгийн газрын бүрэн эрхт төлөөлөгчөөр Н.Тавинбэхийг томилсон.

Аваар, осол улмаас гэмтсэн тоног төхөөрөмж, барилга байгууламжийг тусгаарлах, хохирлын хэмжээг тодорхойлон үнэлгээг гаргах, дулаан хангамжийн системийн ослын шалтгааныг тодорхойлох, холбогдох мэргэжлийн байгууллагын дүгнэлт гаргуулах, шатсан барилга, тоног төхөөрөмжийг цаашид ашиглах боломжтой эсэхийг ялган тооюу ажил үргэлжилж байна.

Эрчим хүчний сайдын 2025 оны А/145 тушаалаар “Дулааны III цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компанийн 2025 оны техник, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг шинэчлэн баталсан байна.

ШИЙДВЭРЛЭСЭН нь:

“Дулааны III цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компанийн доорх арга хэмжээг авах:

1.Хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор гэмтсэн, нурсан барилга байгууламжийг буулгах, нураах, их засвар шинэчлэл хийх, сэргээн засварлах, ашиглах боломжгүй болсон тоноглолыг салгаж буулгах, худалдан авах, угсрах, суурилуулах ажлыг цаг алдалгүй хийх;

2.Аваар, ослын улмаас гэмтсэн тоног төхөөрөмж, барилга байгууламжийг тусгаарлах, хохирлын хэмжээг тодорхойлон үнэлгээг хийх, дулаан хангамжийн системийн ослын шалтгааныг тодорхойлох, холбогдох мэргэжлийн байгууллагын дүгнэлт гаргуулж хохирлыг хэмжээг тодорхой болсны үндсэн дээр акталж, данснаас хасах асуудлыг шийдвэрлүүлэх нь зүйтэй гэж үзэв” гэжээ.

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР

132320011

15-r huraldaan.docx